



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Алтай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **БӨА-2022/19/НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Өлгий хот 2022 он</p>	<p>Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn Аудитор: Ж.Назгүл Утас: 99668909 Цахим хаяг: nazgulj@audit.gov.mn</p>
---------------------------------------------------------------------------------------------------	------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1. Аудитын санал дүгнэлт .....	<b>Error! Bookmark not defined.</b>
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Материаллаг байдал .....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал .....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт .....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	17

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgii@audit.gov.mn

АЛТАЙ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
1 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
Ц.АЛТАЙБАЯР ТАНАА

2022.02.25 № 285  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Алтай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Алтай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

1. Санхүүгийн тайланд тусгагдсан 1.14.7 сая төгрөгийн бараа материал, 327.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдлийн тооллого хийгдээгүй, тооллогын дүнгээр хөрөнгийн үлдэгдлийг хянаж баталгаажуулаагүй, тайлант хугацааны 1-12 дугаар сарын 1458.1 сая төгрөгийн цалингийн цэсийг гаргаж ирүүлээгүй тул цалингийн зардлыг тулган шалгах боломжгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, 26 дугаар зүйлийн 26.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.2, 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 14 дүгээр зүйлийн 14.3, 14.3.1, 14.3.2, 14.3.3, 20 дугаар зүйлийн 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 2 дахь заалттай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, толилуулга, тохиолдсон байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.ХУАНГАН

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>103,846,799.82</u></b>	<b><u>119,335,188.32</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	4,599,860.67	4,599,860.67
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	3,135,510.67	3,135,510.67
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	1,464,350.00	1,464,350.00
3351	Байгууллагаас авах авлага	1,464,350.00	1,464,350.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	99,246,939.15	114,735,327.65
35300	Бэлэн бүтээгдэхүүн	365,600.00	7,125,060.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	98,881,339.15	107,610,267.65
35410	Бичиг хэргийн материал		
35420	Аж ахуйн материал	30,611,480.00	34,300,296.00
35430	Сэлбэг хэрэгсэл		
35440	Түлш, шатах тослох материал	1,094,774.00	163,240.00
35450	Барилгын засварын материал		
35460	Хүнсний материал	24,782,216.15	37,408,862.65
35470	Бусад хангамжийн материал	42,392,869.00	35,737,869.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>3,743,241,008.23</u></b>	<b><u>3,705,863,618.96</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	3,743,241,008.23	3,705,863,618.96
391	Газар		
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	3,667,447,008.23	3,630,069,618.96
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,684,810,534.68	3,676,810,534.68
39202	Хуримтлагдсан элэгдэл	(174,401,841.86)	(232,768,998.86)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	107,296,130.00	131,922,830.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(87,386,234.68)	(90,800,497.51)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	130,887,343.00	139,160,495.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(45,525,776.91)	(50,528,278.35)
39217	Ном	51,766,854.00	56,273,534.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	75,794,000.00	75,794,000.00
39301	Програм хангамж	550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(550,000.00)	(550,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	75,794,000.00	75,794,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>3,847,087,808.05</u></b>	<b><u>3,825,198,807.28</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>-</u></b>	<b><u>573,446.82</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	573,446.82
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	573,446.82
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		573,446.82
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>3,847,087,808.05</u></b>	<b><u>3,824,625,360.46</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	3,847,087,808.05	3,824,625,360.46
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	806,413,406.50	806,413,406.50
51101	Өмч: - төрийн	806,413,406.50	806,413,406.50
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	683,719,427.71	661,256,980.12
51210	Өмнөх үеийн үр дүн	683,719,427.71	683,719,427.71
51220	Тайлант үеийн үр дүн		(22,462,447.59)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,356,954,973.84	2,356,954,973.84

6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>3,847,087,808.05</u></b>	<b><u>3,825,198,807.28</u></b>
---	----------------------------------------------------	--------------------------------	--------------------------------

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,713,879,904.46</b>	<b>1,797,525,950.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,510,459,628.46</b>	<b>1,572,174,500.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	45,268,528.46	-
120002	Хүүгийн орлого	20,033.46	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	45,248,495.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	45,248,495.00	
<b>123</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	1,465,191,100.00	1,572,174,500.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	1,465,191,100.00	1,572,174,500.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>203,420,276.00</b>	<b>225,351,450.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	-	46,563,554.00
131005	Хөрөнгийн санхүүжилт		46,563,554.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	7,000,000.00	11,873,896.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,000,000.00	11,873,896.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	173,062,500.00	166,914,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	173,062,500.00	166,914,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	23,357,776.00	-
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт	23,357,776.00	
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,766,801,810.55</b>	<b>1,814,030,581.96</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,766,801,810.55</b>	<b>1,814,030,581.96</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,713,810,001.09	1,786,016,941.96
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,207,280,894.95	1,283,958,300.00
210101	Үндсэн цалин	1,080,920,494.95	1,179,061,124.00
210102	Нэмэгдэл	117,284,800.00	95,821,576.00
210105	Гэрээт ажлын хөлс	9,075,600.00	9,075,600.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	157,353,821.38	174,122,746.82
210201	Тэтгэврийн даатгал	110,699,821.38	122,756,746.82
210202	Тэтгэмжийн даатгал	11,663,100.00	12,841,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,330,900.00	10,273,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,332,800.00	2,568,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	23,327,200.00	25,683,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	171,588,150.00	163,491,438.00
210301	Гэрэл, цахилгаан	3,727,250.00	1,837,904.00
210302	Түлш, халаалт	167,860,900.00	161,653,534.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	10,282,113.00	13,835,854.00
210401	Бичиг хэрэг	1,022,000.00	3,353,800.00
210402	Тээвэр, шатахуун	3,487,300.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	350,000.00	660,000.00
210404	Ном, хэвлэл	193,800.00	3,323,674.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,229,013.00	6,498,380.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	66,489,806.00	61,287,853.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	180,000.00	
210502	Хоол, хүнс	54,745,376.00	50,992,353.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	11,564,430.00	10,295,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	864,000.00
210604	Урсгал засвар		864,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,759,400.00	488,000.00
210702	Дотоод албан томилолт	1,759,400.00	488,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	948,000.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	198,000.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	750,000.00	
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	98,107,815.76	87,968,750.14
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,139,900.00	5,096,796.50
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	94,967,915.76	82,871,953.64
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	52,991,809.46	28,013,640.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	39,866,176.00	23,982,340.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	23,357,776.00	
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	16,508,400.00	23,982,340.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	20,033.46	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,033.46	
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	13,105,600.00	4,031,300.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,105,600.00	4,031,300.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>(52,921,906.09)</u></b>	<b><u>(16,504,631.96)</u></b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	9,097,425.95	5,957,815.63
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	9,097,425.95	5,957,815.63
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	(9,097,425.95)	(5,957,815.63)
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>(62,019,332.04)</u></b>	<b><u>(22,462,447.59)</u></b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	806,413,406.50	2,356,954,973.84	683,719,427.71		3,847,087,808.05
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	806,413,406.50	2,356,954,973.84	683,719,427.71	-	3,847,087,808.05
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
C07	Тайлант үеийн үр дүн					-
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	806,413,406.50	2,356,954,973.84	683,719,427.71	-	3,847,087,808.05
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	806,413,406.50	2,356,954,973.84	683,719,427.71	-	3,847,087,808.05
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	806,413,406.50	2,356,954,973.84	683,719,427.71	-	3,847,087,808.05
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					-
D08	Тайлант үеийн үр дүн			(22,462,447.59)		(22,462,447.59)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	806,413,406.50	2,356,954,973.84	661,256,980.12	-	3,824,625,360.46

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>1,668,631,409.46</u></b>	<b><u>1,750,962,396.00</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,465,211,133.46</b>	<b>1,572,174,500.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	20,033.46	-
120002	Хүүгийн орлого	20,033.46	
<b>123</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	1,465,191,100.00	1,572,174,500.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	1,465,191,100.00	1,572,174,500.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>203,420,276.00</b>	<b>178,787,896.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	7,000,000.00	11,873,896.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,000,000.00	11,873,896.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	173,062,500.00	166,914,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	173,062,500.00	166,914,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	23,357,776.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	23,357,776.00	
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>1,661,864,509.46</u></b>	<b><u>1,742,871,896.00</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,661,864,509.46</b>	<b>1,742,871,896.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,608,507,100.00</b>	<b>1,708,544,896.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,210,158,200.00	1,284,147,600.00
210101	Үндсэн цалин	1,083,797,800.00	1,201,095,300.00
210102	Нэмэгдэл	117,284,800.00	73,976,700.00
210105	Гэрээт ажлын хөлс	9,075,600.00	9,075,600.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	157,458,400.00	173,360,000.00
210201	Тэтгэврийн даатгал	110,804,400.00	121,994,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	11,663,100.00	12,841,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,330,900.00	10,273,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,332,800.00	2,568,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	23,327,200.00	25,683,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	172,062,500.00	165,914,000.00
210301	Гэрэл, цахилгаан	5,191,600.00	5,192,000.00
210302	Түлш, халаалт	166,870,900.00	160,722,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	9,277,500.00	10,567,440.00
210401	Бичиг хэрэг	1,290,300.00	427,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,470,300.00	2,244,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,223,000.00	1,507,500.00
210404	Ном, хэвлэл	193,800.00	299,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,100,100.00	6,088,440.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	52,170,500.00	66,556,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	383,100.00	861,900.00
210502	Хоол, хүнс	47,001,500.00	63,519,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,785,900.00	2,175,600.00

<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,000,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,759,400.00	488,000.00
210702	Дотоод албан томилолт	1,759,400.00	488,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	948,000.00	1,325,556.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	198,000.00	725,556.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	750,000.00	600,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	3,672,600.00	5,185,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,672,600.00	5,185,800.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>53,357,409.46</b>	<b>34,327,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	40,231,776.00	30,295,700.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	23,357,776.00	
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	16,874,000.00	30,295,700.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	20,033.46	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,033.46	
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	13,105,600.00	4,031,300.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,105,600.00	4,031,300.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>6,766,900.00</u></b>	<b><u>8,090,500.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>6,766,900.00</b>	<b>8,090,500.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>6,766,900.00</b>	<b>8,090,500.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	6,766,900.00	8,090,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,766,900.00	8,090,500.00
<b>2260</b>	<b>Гадаад эх үүсвэрээр</b>	-	-
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(6,766,900.00)</u></b>	<b><u>(8,090,500.00)</u></b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>=</u></b>	<b><u>=</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	-
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,739,088,500.00</b>	<b>1,735,057,200.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,739,088,500.00</b>	<b>1,735,057,200.00</b>

<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,704,949,000.00</b>	<b>1,704,761,500.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,284,147,600.00</b>	<b>1,284,147,600.00</b>
210101	Үндсэн цалин	1,201,095,300.00	1,201,095,300.00
210104	Урамшуулал	73,976,700.00	73,976,700.00
210105	Гэрээт ажлын хөлс	9,075,600.00	9,075,600.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>173,360,000.00</b>	<b>173,360,000.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	121,994,000.00	121,994,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	12,841,500.00	12,841,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,273,200.00	10,273,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,568,300.00	2,568,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	25,683,000.00	25,683,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>165,914,000.00</b>	<b>165,914,000.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	5,192,000.00	5,192,000.00
210302	Түлш, халаалт	160,722,000.00	160,722,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>6,396,900.00</b>	<b>6,396,900.00</b>
210401	Бичиг хэрэг	427,000.00	427,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,837,500.00	1,837,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,507,500.00	1,507,500.00
210404	Ном, хэвлэл	609,900.00	609,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,015,000.00	2,015,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>67,059,200.00</b>	<b>66,871,700.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	451,900.00	451,900.00
210502	Хоол, хүнс	63,706,500.00	63,519,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,900,800.00	2,900,800.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,000,000.00</b>	<b>1,000,000.00</b>
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>488,000.00</b>	<b>488,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	488,000.00	488,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,209,900.00</b>	<b>1,209,900.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	609,900.00	609,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	600,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>5,373,400.00</b>	<b>5,373,400.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,373,400.00	5,373,400.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>34,139,500.00</b>	<b>30,295,700.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>34,139,500.00</b>	<b>30,295,700.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	34,139,500.00	30,295,700.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,739,088,500.00</b>	<b>1,735,057,200.00</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,572,174,500.00</b>	<b>1,568,143,200.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,572,174,500.00	1,568,143,200.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих		
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>166,914,000.00</b>	<b>166,914,000.00</b>
132001	Орон нутгийн төсвөөс	166,914,000.00	166,914,000.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>11,873,896.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>11,873,896.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	11,873,896.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	9,007,100.00
210401	Бичиг хэрэг	5,600,000.00
210402	Тээвэр, шатахуун	407,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,000,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	410,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	410,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	463,896.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	463,896.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1,992,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,992,900.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>11,873,896.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>11,873,896.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,873,896.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Алтай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Алтай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян-Өлгий аймаг дахь төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Алтай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн нь: “Хүүхдийн хөгжлийг дэмжих, суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилгах, амжилттай суралцахад бүх талын хамтын ажиллагаа, оролцоог хангаж хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах” гэсэн зорилго тавьж ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба ажилладаг бөгөөд тайлант онд тус байгууллагад шалгалт хийгээгүй байна.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алтай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 1743.4 сая төгрөгөөс 1 хувиар буюу 17.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 13.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Алтай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 21.9 сая төгрөгөөр буюу 0.6 хувиар буурсан байна. Өмнөх оноос материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

*/мянган төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	4,599.8	4,599.8	0
Урьдчилгаа			
Бараа материал	99,246.9	114,735.3	15,488.4
Үндсэн хөрөнгө	3,743,241.0	3,705,863.6	37,377.4
<b>Нийт хөрөнгө</b>	<b>3,847,087.8</b>	<b>3,825,198.8</b>	<b>-21,889.0</b>
Өр төлбөр	0	573.4	573.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,847,087.8	3,824,625.4	-2,262.4
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>3,847,087.8</b>	<b>3,825,198.8</b>	<b>-21,889.0</b>

Мөнгөн хөрөнгө данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна. Авлага дансны үлдэгдэл 4.6 сая төгрөг нь өмнөх оноос дамжиж ирсэн бөгөөд гэрэл цахилгаанд 1.5 сая төгрөг, цалингийн татварт 2.8 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 0.3 сая төгрөгийн авлагатай байна. Аудитаар тайлант оны цалингийн баримт материалыг ирүүлээгүй тул цалинтай холбоотой гарсан авлагыг баталгаажуулах боломжгүй байлаа.

Бараа материалын дансны үлдэгдэл 114.7 сая төгрөг болж 15.5 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр нийт 110.5 сая төгрөгийн бараа материал худалдан авч үйл ажиллагаандаа 83.6 сая төгрөгийн материалыг зарцуулсантай холбоотой байна. Жилийн эцэст 114.7 сая төгрөгийн бараа материалын үлдэгдлийн тооллого хийгдээгүй байна.

Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 3.0 сая төгрөгийн ус буцалгагчийг хүлээн авч данс бүртгэлд тусгаж, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдөр 35 дугаар тогтоолоор 7.7 сая төгрөгийн аж ахуйн материал, 6.6 сая төгрөгийн бусад хангамжийн материалыг акталж данснаас хассан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3705.8 сая төгрөг болж 37.4 сая төгрөгөөр өссөн байна. Төсвийн хөрөнгөөр 2.2 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 5.9 сая төгрөгийн тавилгыг худалдан авч, сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 10.0 сая төгрөгийн тавилга, БСШУС-ын багцын хөрөнгө оруулалтаар 26.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 17.9 сая төгрөгийн тавилга, аймгийн БСУГ-аас 1.8 сая төгрөгийн ном, нийт 46.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэгүй хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 133 дугаар тогтоолоор элэгдлээ бүрэн нөхсөн 8.0 сая төгрөгийн барилга байгууламж, 4.5 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, 9.6 сая төгрөгийн тавилга эд хогшил, 3.2 сая төгрөгийн номыг акталж, данс бүртгэлээс хассан байна. Жилийн эцэст 327.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдлийн тооллого хийгдээгүй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 0.6 сая төгрөг болж өссөн ба 0.3 сая төгрөг нь үйлдвэрчний эвлэлийн татварын, 0.3 сая төгрөг нь НДШ-ийн өглөг байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 3824.6 сая төгрөг болж өмнөх оны үлдэгдлээс 22.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Алтай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны анх батлагдсан төсөв 1613.5 сая төгрөг, тодотгосон төсөв 1739.1 сая төгрөг байна.

Анх баталсан төсвийг 125.5 сая төгрөгөөр бууруулж тодотгож баталсан байна. Тодруулбал цалингийн зардлыг 218.7 сая төгрөгөөр, НДШ-ийн 29.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж, хоолны зардлыг 102.7 сая төгрөгөөр, үдийн хоолны зардлыг 20.0 сая төгрөгөөр бууруулж тодотгосон байна.

Энэ нь анх баталсан төсөвт цалингийн зардлыг 144.7 сая төгрөгөөр, НДШ-ийн зардлыг 29.5 сая төгрөгөөр дутуу суулгаж, нэмэгдэл, урамшлын 73.9 сая төгрөгийн зардлыг төсөвт суулгаагүй байсантай холбоотой байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд нийт 1739.1 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр үйл ажиллагаандаа 1735.0 сая төгрөгийг зарцуулж, хоолны зардлын батлагдсан төсвийг 0.2 сая төгрөгөөр, үдийн цайны зардлыг 3.8 сая төгрөгөөр, нийт 4.0 сая төгрөгөөр хэмнэж төсөвт төвлөрүүлсэн байна.

Нийт төсвийн 74 хувийг цалин, 10 хувийг НДШ-ийн зардал, 9.5 хувийг тогтмол зардал, 0.4 хувийг хангамж бараа материалын зардал, 3.8 хувийг нормативт зардал, 0.06 хувийг урсгал засварын зардал, 0.03 хувийг дотоод томилолтын зардал, 0.3 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, 0.3 хувийг бараа үйлчилгээний бусад зардал 1.7 хувийг урсгал шилжүүлгийн зардал тус тус эзэлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд сумын Орон нутгийн хөгжлийн сангаас 3.0 сая төгрөг, аймгийн БСУГ-аас тэтгэлэгт хөтөлбөрийн зардалд 8.0 сая төгрөгийн, ариутгалын зардалд 0.5 сая төгрөгийн, 0.4 сая төгрөгийн бичиг хэргийн зардалд, нийт 11.8 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авчээ.

Үүнээс бичиг хэргийн зардалд 5.6 сая төгрөгийг, тээвэр шатахууны зардалд 0.4 сая төгрөгийг, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардалд 3.0 сая төгрөгийг, эм бэлдмэлийн зардалд 0.4 сая төгрөгийг, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 0.5 сая төгрөгийг, хичээл үйлдвэрлэл дадлагын зардалд 2.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Алтай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайланд тусгагдсан 114.7 сая төгрөгийн бараа материал, 327.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдлийн тооллого хийгдээгүй асуудлыг үнэн зөвөөр толилуулж, тодруулаагүй байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар тайлант хугацааны 1-12 дугаар сарын 1458.1 сая төгрөгийн цалингийн цэсийг гаргаж ирүүлээгүй байдал нь аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсгэсэн болно.

Алтай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 2021 онд гүйцэтгэлээр нийт 1735.1 сая төгрөгийн санхүүжилтийг үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1-д зааснаар үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад зардлын батлагдсан төсөв 17.8 сая төгрөгийн батлагдсан төсвийн 10 хувь буюу 1.7 сая төгрөгийн хэмнэлт гаргахаар тооцож урсгал зардлыг төлөвлөж зарцуулаагүй, тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд 2021 оны санхүүгийн тайланд үлэмж нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл гараагүй байна.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Алтай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 2021 онд нийт 1739.1 сая төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 1576.5 сая төгрөгийн 108 мэдээллийг хугацаанд байршуулж, 41 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Шилэн дансны мэдээлэл байршуулсан байдал 72.5 хувьтай байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудад нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх санхүүгийн аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, авлага, хүнсний материалын үлдэгдэлтэй холбоотой 7.9 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж, 12 албан шаардлага хүргүүлсэн байна. Зөвлөмжийн биелэлтийг Алтай сумын Ерөнхий

боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны 09-р сарын 13-ны өдрийн 13, 14 тоот албан бичгээр ирүүлжээ.

Аудитаар шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байсан тул албан шаардлага хүргүүлэв.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар хөрөнгийн тооллого, нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой асуудлыг анхаарч үзэх шаардлагатай. Санхүүгийн тайлангийн аудитыг эрсдэлтэй данс, ажил гүйлгээг сонгож үзсэн тул төсвийн зарцуулалтыг гүйцэтгэлийн шалгалтаар дэлгэрэнгүй үзэх шаардлагатай байна.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 1,986.9 сая төгрөгийн зөрчил илэрч 20.6 сая төгрөгийн зөрчлийг залруулж, 1,964.9 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага, 1.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоов.

### **4.1 Залруулсан алдаа**

Санхүүгийн тайланд дараах залруулга хийгдсэн болно. Үүнд: Санхүүгийн үр дүнгийн тайлан Төсвийн гүйцэтгэлийн тайлан, нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайланд дараах залруулга хийгдсэн болно. Үүнд:

1. Санхүүгийн үр дүнгийн тайлангаар хоолны зардлыг 0.2 сая төгрөгөөр, төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшууллын зардлыг 3.8 сая төгрөгөөр, хичээл үйлдвэрлэл дадлагын зардлыг 0.1 сая төгрөгөөр илүү, төвлөрүүлсэн шилжүүлгийг 4.1 сая төгрөгөөр дутуу тайлагнасныг залруулав

2. Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн санхүүжүүлэх эх үүсвэрийг 1568.1 сая төгрөгөөр дутуу, бичиг хэргийн зардал, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийн зардал, хичээл үйлдвэрлэл дадлагын зардал, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ, нормын хувцас зөөлөн эдлэл зэрэг зардлуудын гүйцэтгэлийг зөрүүтэй тайлагнасныг залруулав.

3. Нэмэлт төсвийн санхүүжилтийн 11.9 сая төгрөгийн тайланг ирүүлээгүй тул залруулж гаргав.

### **4.2 Төлбөрийн акт**

Аудитаар 1.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоов. Үүнд:

1. Сургуулийн дотуур байрны хүүхдүүдэд 2021 оны 1-12 дугаар сард 13005 хүүхэд өдөрт нийтдээ 51.0 сая төгрөгийн хүнсний материал зарцуулсан ба Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоолоор батлагдсан хүүхдийн нэг өдрийн хоолны зардлын нормоор тооцож үзэхэд дотуур байрны хүүхдийн нэг өдрийн хоолны зардалд дунджаар 4178 төгрөг зарцуулж, жилийн дүнгээр батлагдсан нормыг 1.4 сая төгрөгөөр хэтрүүлэн төсвөөс хууль бусаар илүү зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, 45 дугаар зүйлийн 45.2-т “Төсвийн захирагчийн төсвийг дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, 45.2.1-д “нэгжид ногдох норм, нормативаар тооцон төсвийг нь баталсан ба гүйцэтгэл нь анх тооцсон нэгжийн тоо хэмжээнээс бага бол”, Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоолоор баталсан “Хоолны зардлын дундаж норматив батлах тухай” журмын 2-т “Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд амьдрах нэг хүүхдийн хоолны зардлыг 3475 төгрөгөөр тогтоосугай” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан нормоос хэтрүүлсэн зарцуулсан хоолны зардлыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

### 4.3 Албан шаардлага

Аудитаар 1964.9 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Алтай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 2021 онд гүйцэтгэлээр нийт 1735.0 сая төгрөгийн санхүүжилтийг үйл ажиллагаандаа зарцуулсан ба Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1-д зааснаар үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад зардлын батлагдсан төсөв 17.8 сая төгрөгийн батлагдсан төсвийн 10 хувь буюу 1.7 сая төгрөгийн хэмнэлт гаргахаар тооцож урсгал зардлыг төлөвлөж зарцуулаагүй тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст оруулбал зохих 149 мэдээллээс 41 мэдээллийг хугацаа хоцроож оруулсан, Шилэн дансны мэдээлэл байршуулсан байдал 72.5 хувьтай байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, 6.4.1, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4 дэх заалт, Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлж ажиллах талаар албан шаардлага өгөв.

2. Сургуулийн захирлын 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А/54 дүгээр тушаалаар жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийх ажлын хэсэг байгуулсан боловч 114.7 сая төгрөгийн бараа материал, 327.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдлийн тооллого хийгдээгүй, нягтлан бодогч нь тооллогын дүнгээр хөрөнгийн тооцоо бодсон акт үйлдэж, хөрөнгийн үлдэгдлийг баталгаажуулаагүй.

Аудитын хугацаанд 1-12 дугаар сарын 1,458.0 сая төгрөгийн цалингийн цэсийг гаргаж ирүүлээгүй тул цалингийн зардлын дүнг тулган шалгах, нийгмийн даатгалын шимтгэл, цалингаас суутгасан татварын тооцоог хийх боломжгүй байна.

Тайлант онд үдийн цай, үдийн хоолны зардалд 30.3 сая төгрөгийн төсвийг 19156 хүүхдэд зарцуулж, оны эцэст 7.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан боловч санхүүгийн программд бөөн дүнгээр орлогод авч, зарлага гаргасан, Тээвэр шатахууны зардалд 1.7 сая төгрөгийн нэхэмжлэл хүлээн авч 1.2 сая төгрөгийг нэхэмжилсэн дүнгээс илүү шилжүүлж санхүүгийн тайланд авлагаар харуулаагүй, Гэрэл цахилгааны зардлын батлагдсан төсвөөс 3.3 сая төгрөгийг зохих зөвшөөрөлгүйгээр аж ахуйн материалын зардалд шилжүүлэн зарцуулсан, жижиг мөнгөн санд 6.5 сая төгрөгийг бүрдэл дутуу баримтаар зарцуулсан, 4 дүгээр улирлын үр дүнгийн урамшуулал, үйлдвэрчний эвлэлийн татварт шилжүүлсэн 22.7 сая төгрөгийн ажил гүйлгээг тооцооны данс дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсгийн 41.2.2, 41.2.3, 42 дугаар зүйлийн 42.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.2, 12.2.1, 13.7, 14 дүгээр зүйлийн 14.3, 14.3.1, 14.3.2, 14.3.3, 14.4, 14.4.1, 14.4.2, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 2 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар албан шаардлага өгөв.

### 4.4 Зөвлөмж

Аудитаар өгсөн зөвлөмж байхгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль	6	1986.9	3	20.6	1	1.4	2	1964.9		